



## БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЙДЫН ТУШААЛ

2020 оны 02 сарын 04 өдөр

Дугаар 23

Улаанбаатар хот

### Төрийн зарим чиг үүргийг гэрээгээр үргэлжлүүлэн гүйцэтгүүлэх тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Барилгын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.4. дэх заалт, 19 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, 34 дүгээр зүйлийн 34.1.1, 34.1.14 дэх заалт, мөн зүйлийн 34.2 дахь хэсэг, 36 дугаар зүйлийн 36.1 дэх хэсэг, Засгийн газрын 2010 оны 325 дугаар тогтоол, Төрийн бус байгууллагуудаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж буй үйл ажиллагааны тайлангийн 2020 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн 2020/001 дугаар хурлын тэмдэглэлийг тус, тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Барилгын материалын үйлдвэрлэл эрхлэх хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааг зохион байгуулах” чиг үүргийг “Монголын барилгын материал үйлдвэрлэгчдийн холбоо” төрийн бус байгууллагаар гэрээний үндсэн дээр үргэлжлүүлэн гүйцэтгүүлсүгэй.

2. “Барилгын материалын үйлдвэрлэл эрхлэх хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааг зохион байгуулах” чиг үүргийг гүйцэтгүүлэх гэрээг 3 жилийн хугацаатай “Монголын барилгын материал үйлдвэрлэгчдийн холбоо” төрийн бус байгууллага /М.Түмэнжаргал/-тай байгуулж, хэрэгжилтэд хяналт тавьж, удирдлага, зохицуулалтаар хангаж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /С.Магнайсүрэн/-д даалгасугай.


3. Барилгын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, Барилга, хот байгуулалтын сайдын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 217 дугаар тушаалаар баталсан “Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилгын ажил гүйцэтгэх, барилгын материалын үйлдвэрлэл, өргөх байгууламж түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, хяналт тавих журам”-ыг өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг “Монголын барилгын материал үйлдвэрлэгчдийн холбоо” төрийн бус байгууллага /М.Түмэнжаргал/-д үүрэг болгосугай.

4. Дээрх чиг үүргийг гэрээний үндсэн дээр хэрэгжүүлэхтэй холбогдуулан төр хувийн хэвшлийн түншлэлийн зарчмаар хамтын ажиллагааг өргөжүүлэн барилгын салбарын ажилтны мэдээллийн санг хамтран ашиглаж барилгын материалын

151010073

үйлдвэрлэлийн чиглэлээр баяжилтыг тогтмол хийж хамтран ажиллахыг “Монголын барилгын материал үйлдвэрлэгчдийн холбоо” төрийн бус байгууллага /М.Түмэнжаргал/, “Барилгын хөгжлийн төв” ТӨААТҮГ-ын захирал /Ц.Амарсанаа/ нарт даалгасугай.

5. Энэ тушаал гарсантай холбогдуулан Барилга, хот байгуулалтын сайдын 2019 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн 21 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

  
Х.БАДЕЛХАН

**ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГУУДААР ГЭРЭЭНИЙ ҮНДСЭН ГҮЙЦЭТГҮҮЛЖ БУЙ ҮЙЛ  
АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАНГИЙН ХУРАЛ**

2020 оны 01 сарын 13-ны өдөр

Дугаар 2020/001

Улаанбаатар хот

Хурал 2020 оны 01 дүгээр сарын 13-ны өдөр БХБЯ-ны хурлын өрөөнд 10:00 цагаас 13:00 цагийн хооронд болов.

**ХЭЛЭЛЦСЭН НЬ:**

1. "Монголын барилгын үндэсний ассоциаци" ТББ-ын 2019 оны үйл ажиллагааны тайлан;
2. "Монголын барилгын материал үйлдвэрлэгчдийн холбоо" ТББ-ын 2019 оны үйл ажиллагааны тайлан;
3. "Монголын архитекторуудын эвлэл" ТББ-ын 2019 оны үйл ажиллагааны тайлан;
4. "Монголын барилгачдын нэгдсэн холбоо" ТББ-ын 2019 оны үйл ажиллагааны тайлан.

**Хуралд:** Төрийн нарийн бичгийн дарга С.Магнайсүрэн, ТЗУГ-ын дарга Д.Баярсайхан, БТГ-ын дарга Ц.Баярбат, ББМУБХЗГ-ын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Гантулга, НААБХҮГ-ын дарга О.Лхагвацэдэн, ХШҮДАГ-ын дарга Н.Нарантуяа, ХОҮХ-ийн дарга Б.Алтайбаатар, Хуултийн хэлтсийн дарга Б.Нямдорж, ТЗУГ-ын ахлах шинжээч А.Лхамсэржид, ББМУБХЗГ-ын ахлах шинжээч Д.Батзориг болон ТББ-ууд төлөөллүүд оролцлоо.

**С.Магнайсүрэн:**

Сайн байцгаана уу. Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргье. МБҮА тайлангаа танилцуулж эхэлнэ үү.

М.Энхбаатар: Та бүгдэд энэ өдрийн мэнд хүргье.

Монголын барилгын үндэсний ассоциаци" ТББ нь "Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилгын ажил гүйцэтгэх, өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар үйлчилгээ эрхлэх хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл олгох" үйл ажиллагааг Барилга хот байгуулалтын сайдын 2018 оны 216, 2019 оны 9 дүгээр тушаал, Барилга, хот байгуулалтын яамтай байгуулсан гэрээний үндсэн дээр салбарын бусад ТББ-уудын түншлэлийн хамтаар гүйцэтгэж байна.

Монголын барилгын үндэсний ассоциацийн ерөнхийлөгчийн Т-18/02 дугаар тушаалаар МБҮА-ийн ажлын албаны дэргэд Барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн хэлтсийг 2018 оны 02 дугаар сарын 09-ний өдөр байгуулсан бөгөөд тус хэлтэс нь өөрийн "Нэг цэгийн үйлчилгээний төв"-өөр дамжуулан 2018 онд 2200, 2019 онд 2200 гаруй аж ахуй нэгж, байгууллага, иргэдэд үйлчлэв.

БҮАТЗ олгоход Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, Барилгын тухай хууль болон БХБ-ын Сайдын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн "Дүрэм шинэчлэн батлах тухай" 218 дугаар тушаал, 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн "Журам шинэчлэн батлах тухай" 217 дугаар тушаал, 2018 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн "Аргачлал батлах тухай" 33 дугаар тушаалаар батлагдсан хууль, дүрэм, журмуудыг мөрдөн ажиллаж байна.

Монголын барилгын үндэсний ассоциацийн ерөнхийлөгчийн 2019 оны 08 дугаар 19-ний Т-19/03 дугаар тушаалаар Барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл олгох асуудлаар урьдчилсан дүгнэлт гаргах Ажлын хэсгийг шинэчлэн байгуулсан ба тус Ажлын хэсэг нь 7 хоног бүр тогтмол хуралдаж байна. 2018 онд нийт **39** удаагийн хурлаар **2187**, 2019 онд **46** удаагийн хурлаар **2010** аж ахуй нэгж байгууллагын материалтай танилцаж, дүрэм, журмын дагуу шийдвэр гаргав.

Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилгын ажил гүйцэтгэх, өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн өргөдлийг 2019 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн [www.tz.mnca.mn](http://www.tz.mnca.mn) сайтаар цахимаар хүлээн авч шийдвэрлэж эхлээд байна.

БҮАТЗ-тэй холбоотой "Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилгын ажил гүйцэтгэх, барилгын материалын үйлдвэрлэл, өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, тэдгээрт хяналт тавих, барилгын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжид тавих шаардлага, бүртгэх журам"-ын дагуу тусгай зөвшөөрөл хүссэн давхардсан тоогоор **2010** аж ахуйн нэгж, байгууллагын өргөдөл материалыг хүлээн авч судлан "Тусгай зөвшөөрөл олгох асуудлаар урьдчилсан дүгнэлт гаргах ажлын хэсэг"-ийн **46** удаагийн хуралд танилцуулга бэлтгэн хэлэлцүүлэв.

**2019** оны **46** удаагийн хурлаар БҮАТЗ хүссэн нийт **2010** ААНБ-ын өргөдөл материал хэлэлцэгдэж **1603** ААНБ-ын өргөдөл материал дэмжигдэв. Үүнээс сунгалтаар **381**, шинээр **838**, нэмэлтээр **334**, дахин олголтоор **50** ААНБ-д БҮАТЗ олголоо.

Сунгалтаар **381** ААНБ-д БҮАТЗ олгосноос Барилга угсралтаар **303**, Зураг төсөл боловсруулахаар **64**, Өргөх байгууламжаар **14**, шинээр **838** ААНБ-д БҮАТЗ олгосноос Барилга угсралтаар **711**, Зураг төсөл боловсруулахаар **99**, Өргөх байгууламжаар **28**, нэмэлтээр **334** ААНБ-д БҮАТЗ-ийн ажилбар нэмж олгосноос Барилга угсралтаар **270**, Зураг төсөл боловсруулахаар **620**, Өргөх байгууламжаар **2** ААНБ дэмжигдэв.

Дахин олголтоор **50** ААНБ-д БҮАТЗ олгосноос Барилга угсралтаар **42**, Зураг төсөл боловсруулахаар **7**, Өргөх байгууламжаар **1** ААНБ-д БҮАТЗ-ийн гэрчилгээг дахин олгов.

Эдгээр **46** удаагийн хурлаар **108** ААНБ-ын материалыг тодруулга авахаар түр хойшуулж, **299** ААНБ-ын материалыг шаардлага хангаагүй учраас буцаав.

"Барилга, байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилгын ажил гүйцэтгэх, өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл" шинээр авах, нэмэлт авах, сунгуулах, ИТА хасалт хийлгэх, нэмж бүртгүүлэх, тодорхойлолт хүсэх зэрэг **2,816** албан бичиг, өргөдөл гомдлыг бүртгэн хүлээн авсан.

Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилгын ажил гүйцэтгэх, барилгын материалын үйлдвэрлэл, өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, тэдгээрт хяналт тавих, барилгын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж, байгууллагад тавих шаардлага, бүртгэх журам"-ын дагуу тусгай зөвшөөрөл авахаар хүсэлт ирүүлсэн **9,760** аж ахуйн нэгж, байгууллагын инженер техникийн ажилтны давхцал шалган, **4305** ИТА-нуудыг баталгаажуулж, **616** инженер техникийн ажилтны өргөдлийн дагуу хасалт, шилжилт хөдөлгөөн хийв.

БҮАТЗ олгох асуудлаар урьдчилсан дүгнэлт гаргах Ажлын хэсгийн гишүүдийн Хурлын дүгнэлт, БХБ-ын сайдын тушаалыг үндэслэн **1,588** ААНБ-тай гэрээ байгуулж, Засгийн Газрын "Улсын тэмдэгтийн хураамжийн хувь, хэмжээг тогтоох тухай" 2011 оны №199 дүгээр тогтоолын дагуу **2 016 900 000** төгрөгийн улсын тэмдэгтийн хураамжийг Чингэлтэй дүүргийн татварын хэлтсийн дансанд төвлөрүүлэв.

➤ 2019 онд үйлчилгээний хөлсөнд **1,626** аж ахуйн нэгж, байгууллагаас **317 070 000** төгрөгийг Худалдаа хөгжлийн банкны 431006029 тоот дансанд төвлөрүүлэн ажиллалаа.

Барилгын тусгай зөвшөөрөл сунгуулах, нэмэлт ажилбар авахаар хүсэлт ирүүлсэн аж ахуйн нэгж, байгууллагын тайланг хянаж, тусгай зөвшөөрлийн хугацаанд гүйцэтгэсэн ажлуудын дагуу "Барилгын норм, норматив боловсруулах сангийн шимтгэл"-ийн санд Чингис хаан банкны 3201000004 тоот данс, Улаанбаатар хотын банкны 2600078533 тоот дансуудад нийт **2 544 050 913** төгрөг төвлөрүүлсэн байна.

Мөн олон нийтийн сүлжээгээр үйл ажиллагаагаа сурталчлах чиглэлээр олон ажлуудыг хийж гүйцэтгэсэн.

С.Магнайсүрэн: Хасалт шилжилтийн хөдөлгөөн дээрээ анализ хийж үзээрэй.

М.Энхбаатар: За ойлголоо.

М.Энхбаатар: 2017 оноос эхлээд 5 жилийн хугацаагаар олгоод эхэлсэн. Тэгэхлээр 2019 оны 4 сараас эхлээд 2021 он хүртэл сунгуулах аж ахуйн нэгж байхгүй. Гэхдээ авцан ч гэсэн сунгалтаа өгөөгүй аж ахуйн нэгж байхгүй. Ер нь бол 2020 онд улам буурах хандлагатай. Мөн нормчлолын сангийн төвлөрүүлэлт буурна гэсэн үг.

С.Магнайсүрэн: Энэ бууралт танайд яаж нөлөөлөх вэ.

2019 онд 195-ийг 2 удаа нэмэгдүүлэх хүсэлтийг өгсөн. Дараагийн юм бол нормчлолын сангийн төвлөрүүлэлттэй холбоотой Чингис хаан банк, ХХБ-ны данснуудад төвлөлүүлж байгаа. Зарим зүйлийн талаар УЗ-ийн гишүүд нэмж хэлэх байгаа. Шатлан өгсөх дарааллаар тусгай зөвшөөрлийг олгох асуудлууд байгаа. Туршлагаудыг үндэслэж олгох саналтай байгаа. Хэвлэл мэдээллийн чиглэлээр төлөвлөсөн олон зүйлүүд байгаа.

С.Магнайсүрэн: За манай ажлын хэсгээс нэмж хэлэх юм байна уу. Саяны ярьсантай холбогдуулаад хууль эрх зүйн баримт бичиг байна, Даатгалын систем байна, суурь нөхцөл шөөрдлагын өөрчлөлт байна.

Н.Дорж: Даатгалтай холбоотой хэдэн зүйл хэлчий гэж бодож байна. Энэ бол манайхаас өгсөн санал байгаа юм. БТХ-ийн 8- зүйл дээр даатгал гэж байгаа. Энэ заалтын ойлголтыг нэг мөр болгох хэрэгтэй байгаа юм. ТЗ дээр мэргэшсэн, зөвлөх дээрээ даатгалаа хийгээд ир гэж шаардаж болно. Тусгай зөвшөөрлийн тухай хуулин дээр өөр юм шаардахыг хориглоно гээд заасан байгаа учраас шаардаж чадахгүй байгаа юм. Тэгж байгаа элдэв хохирлуудыг хаах боломж бүрдэнэ. Энэ дээр хамтраад ажиллъя гэсэн санал байгаа. ТЗ-ийг цуцлах үндэслэл бол манайд байхгүй. Хууль эрх зүйн боломж байхгүй байна. Уил болгон чаддаг чаддаггүй хамаагүй хүсэлтүүд өгөөд явдаг. Барилга дээр бас сэргээгдэх хүчний тусгай зөвшөөрөл өгдөг болмоор байна. Эрчим хүч 0-100кв хүртэл өгдөг. Тэрийг бол жижиг байгууллагууд авах боломжгүй шаардлагууд байна.

Зарчмын хувьд ажиллах хүчний тооноосоо давсан байгаа. Нэг байгууллагад 20 хүн ноогдохоор байна.Цаашдын зорилго бол чанаржуулах хууль эрх зүйн очрныг сайжруулах саналууд байгаа юм.

Жүгдэр: Би бол ТЗ-ийн тоо их байна гэж үздэг. Бид нар ТЗ-тэй байгууллагуудыг чанаржуулах талаар анхаарах хэрэгтэй байна. ИБҮБИ инженерийг бэлтгэдэг 16 сургууль байдаг юм байна. Улсын сургуулиас гадна маш муу инженерүүд бэлтгэгдэж байна. Энийг журмалж инженер нь багадаа 2-с дээш жил ажилласан инженерийг тавьж өгөх хэрэгтэй. Энийг бас журамд оруулах хэрэгтэй байна.

Ц.Баярбат: 2 зүйл асуучий. ТЗ-ийн санхүүгийн тайлан байхгүй байна.

Алдагдал ямар байдалтай байна. ТЗ олгогдсон ААНБ-уудын үйл ажиллагааны тайлан ямар байна.

М.Энхбаатар: Тайланг БХТ-д өгч байгаа. Үйл ажиллагаагаа явуулаагүй 3 жил, тайлан өгөөгүй 1 жил болсон ААНБ-уудын мэдээллийг яаманд хүргүүлсэн байгаа. Манай төсвийг яамнаас баталж өгсөн

С.Магнайсүрэн: 315 саятай төлөвлөгөөгөө мөргүүлсэн гэсэн үг үү.

М.Энхбаатар: Тийн мөргүүлсэн.

Д.Баярсайхан: 365 сая гэдэг чинь өмнөх оны үлдэгдэл наад 315 саяд чинь орцон байгаа. Тэрийг бол биелүүлсэн байна гэж харж байна.

С.Магнайсүрэн: Тэрийг бол та нар ажлын шугамаар ярьчих.

Даатгалын асуудлууд бол 44.3.2, 44.3.3 чинь заавал даатгуулах юм байна. Энийг Нямдорж үзээд ажиллах.

С.Магнайсүрэн: За Лхагвадорж тайлангаа тавина уу.

Б.Лхагвадорж: Сайн байцгаана уу. БХБСайдын 2018 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 217 тоот "Журам шинэчлэн батлах тухай" тушаалаар Тусгай зөвшөөрөл авахад шаардагдах суурь нөхцөл шаардлага, бүртгэх журмыг шинэчлэн баталсан бөгөөд зохих журмын дагуу үйл ажиллагаа явуулж урьдчилан дүгнэлт гаргах ажлын Албаны 9 удаагийн хурлын тэмдэглэлийг үндэслэн гарсан Сайдын тушаалаар албажсаны дараа тусгай зөвшөөрлийн гэрчилгээний дугаар, хүчинтэй хугацаа, ажлын хүрээг нийтэд мэдээлж ажиллаж ирлээ. БХБЯ, МБМУХолбооны 2019.02.02-ны 2019/27 тоот гэрээгээр "Барилгын материал, хийц эдэлхүүн, бүтээцийн үйлдвэрлэл эрхлэх хуулийн эдгээдэд тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааг зохион байгуулах"-ыг гүйцэтгэхээр гэрээгээр ажилласан.

БХБЯ, Монголын Барилгын материал үйлдвэрлэгчдийн Холбооны "Барилгын материалын үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагаа"-ны 2019/27 тоот гэрээний хавсралт тооцооны төсвийн гүйцэтгэлийн тайланг бас тус яаманд ирүүлсэн байгаа.

2019 оны жилийн эцсийн байдлаар 92 аж ахуйн нэгж тусгай зөвшөөрөл сунгах, шинээр авах, нэмэлтээр авах асуудлаар хүсэлт гаргаж, зөвлөгөө авснаас 87 аж ахуй нэгжийн асуудлыг тусгай зөвшөөрөл олгох асуудлаар урьдчилсан дүгнэлт гаргах ажлын хэсгийн хурлаар хэлэлцүүлсэн. Нийт 39 аж ахуй нэгж сунгуулсан. 45 аж ахуй нэгж шинээр тусгай зөвшөөрөл авсан. Хариуцлагын талаар: БХБЯ-ны 2019 оны 12 сарын 06-ны 03/4561 тоот "Жи Би эм социал ресерч консалтинг"ХХК-тай хамтарч ажиллах тухай ирүүлсэн тоотын дагуу ажиллаж 2019.12.23-ны 02/176 тоот 2017.03.28-ны өдрийн 52 тоот гэрээ, 2019.02.02-ны 2019/27 тоот гэрээгээр хүлээсэн үүргийн гүйцэтгэлийг гаргаж өгсөн болно.

БХБЯ -тай байгуулсан гэрээний .5 Тусгай зөвшөөрөл олгох асуудлаар дүгнэлт гаргах, хяналт тавих чиг үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнд Барилгын тухай хуулийн

19 дугаар зүйлийн 19.1.4 дэх хэсэгт тусгагдсан материал, хийц, эдэлхүүний үйлдвэрлэлийн чиглэлийн мэргэжлийн холбоодын байгууллагын төлөөлөл болгон ШУТИС-ын дэргэдэх Бетон судлаачдын олон улсын холбоо, Цонх хаалга үйлдвэрлэгчдийн, Дулаалгын EPS хөөсөнцөр хавтан үйлдвэрлэгчдийн, Элс хайрга үйлдвэрлэгч компаниудын зэрэг холбоодоос гадна БХБЯ, БХТ, МХЕГ зэрэг төрийн төлөөлүүдийн оролцоог ханган ажиллаж байна.

Тусгай зөвшөөрөл авч гэрээ байгуулан ажиллаж байгаа аж ахуйн нэгжүүдийн гэрээгээр хүлээсэн үүрэг хариуцлагыг өндөржүүлэх, заавар зөвөлгөө өгөх зорилгоор тусгай зөвшөөрөл олгох асуудлаар урьдчилсан дүгнэлт гаргах ажлын хэсгийн орлогч даргаар ахлуулан, тусгай зөвшөөрөл олгох нэг цэгийн үйлчилгээний ахлах менежер, экспэртийн багийн гишгүүдээс бүрэлдсэн ажлын хэсгийг орон нутагт томилон ажиллуулж байна. Тухайлбал Өмнөговь, Баян-Өлгий, Говь-Алтай, Баянхонгор, Архангай аймгуудад ажилласан нь тодорхой үр дүнгээ өгч орон нутгийн төр, хувийн хэмвшлийн байгуулагуудтай хамтран ажиллаж харилцан мэдээлэл соилцсон нь зохих үр дүнгээ өгч байна. Энэ нэгдүгээр улиралд Зүүн бүсийн, хоёрдугаар улиралд Баруун бүсийн аймгуудаар ажиллахаар төлөвлөж байна.

Нийслэлийн мэргэжлийн хяналтын, Байгаль орчны, Ашигт малтмал, газрын тосны газруудтай хамтран ажиллаж Улаанбаатар хотын дүүргүүдийн аж ахуйн нэгжүүдээр техник технологи, аюулгүй ажиллагаа, агаарын бохирдол, орд газрын нөхөн сэргээлт, эрчим хүчний хэмнэлт, хог хаягдлын менежментийн талаарх ажлын явцыг дүгнэх талаар хамтран ажиллаж байна.

Тусгай зөвшөөрөл авч гэрээ байгуулан ажиллаж байгаа аж ахуйн нэгжүүдийн гэрээгээр хүлээсэн үүрэг хариуцлагыг өндөржүүлэх, заавар зөвөлгөө өгөх зорилгоор технологийн аудит хийх хяналтын хуудас/ чек лист № 1/, үйлдвэрийн лабораторийн дотоод хяналтыг сайжруулах, лаборантуудын ажлын ур чадвар, мэдлэг боловсролыг дүгнэх хяналтын хуудас / чек лист №2/ зохиож Эс Ти Эй ХХК дээр технологийн аудитыг туршилтаар гүйцэтгэн, цаашид боловсронгуй болгох ажил хийгдэж байна. Энэ арга ажиллагаа нь үйлдвэрүүдийг ажлаа эрчимжүүлж чанартай бүтээгдэхүүн тогтвортой үйлдвэрлэх нөхцөл боломжийг илрүүлэх арга хэмжээ болох юм.

2018 оны 7 дугаар сарын 1 нээс мөрдөгдөж эхэлсэн” Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль”ийг амьдралд хэрэгжүүлэх зорилгоор, бүтээгдэхүүн, үйлдвэрлэл, үйлчилгээ, менежментийн тогтолцооны чанар, аюулгүй байдлыг хангах, хэрэглэгч, үйлдвэрлэгчийн эрх ашгийг хамгаалахтай холбогдсон асуудлуудыг Стандартын хэмжил зүйн газрын дэргэдэх барилгын стандартын хороонд холбооны удирдах зөвлөл, холбооны зөвлөх инженерүүдийн оролцоог ханган стандарт боловсруулах, хянаж батлах, амьдралд хэрэгжүүлэх талаар сурталчилгаа явуулах чухал үүрэг гүйцэтгэж байна.

Үйлдвэрлэл архлэх тусгай зөвшөөрөлтэй болон тусгай зөвшөөрлөөс чөлөөлөгдсөн ажлын төрлүүдийн дагуу үйлдвэрлэж байгаа бүтээгдэхүүнийг тохирлын баталгаажуулалтад хамруулах талаар Барилга архитектур корпорац, Барилгын хөгжлийн нэгдсэн төвийн дэрэгдэх баталгаажуулалтын албаны ажлын хэсэгт барилгын материал үйлдвэрлэгчдийн холбооны төлөөллийн оролцоог хангаж идэвхитэй хамтран ажиллаж байна.

С.Магнайсүрэн: Танайхаас би статистик нэхээд байгаа юм. Гантулга энэ асуудлыг сайн анхаарч ажиллах.

Б.Лхагваорж: Оюутолгой шохойг авч байгаа. Манайхаас шохойн чулууны үйлдвэрийн төслийг боловсруулсан. Хөрөнгө оруулалт байхгүй.

С.Магнайсүрэн: Шохойн чулуу хэд болохоор төлөвлөсөн бэ.

Б.Гантулга: 36 орчим байгаа.

Б.Лхагваорж: Бусад нэр төрлийн бүтээгдэхүүнүүд бол хангалттай байгаа.Хөнгөн бетон бас хангалттай. Дүүргэгч материал хүнд асуудалд орсон. УУХҮЯ Баахан элс хайрганы зөвшөөрөл өгөөд эхэллээ. Барилгын үнийг бол маш их өсгөнө. Дарханаас шахах гээд байна. Бүгдийг нь хаачихаад. Ер нь бол зөв явж байгаа байгууллагууд байгаа 34 ААНБ шүүхдээд явж байгаа. Ядаж энэ байгууллагуудаа авч үзмээр байна.

С.Магнайсүрэн: Энэ асуудлаар тусдаа материал бэлдэж удирдлагын зөвлөлд танилцуул.

Б.Лхагваорж: Тусгай зөвшөөрөл дээр бол нарийн мэргэжлийн холбоодоо оруулцан байгаа юу. Хэл ам бол гарахгүй байгаа. Цонхон дээр тодруулга хийе. ШУТИС-ийн эрчим хүчний хэмнэлтийн төвтэй хамтраад шахаж ажиллаж байгаа.

С.Магнайсүрэн: Зарим холбоод чинь авъя энэ тэр гэж хүсэлтүүд ирээд байсан. Норм, нормативын санд үүрэг байгаа юу.

Б.Лхагваорж: Байхгүй.

С.Магнайсүрэн: Орон нутгийн лабораторуудын талаар тодорхой ажлуудыг төлөвлөгөөндөө тусгамаар байна. Мөн энэ 7 хоногийн сүүлээр дэд сайд эхлээд танайх, ХБ-тай хамтраад Бэрэнгийн үйлдвэртэй танилцаад хэдий хэмжээний хөрөнгө шаардагатай эсэх, Дарханы төмөрлөгийн үйлдвэрийн стратегийг яах эсэх талаар зохион байгуулалтыг хийгээд яваад ирмээр байна.

Саяны ажил дээр Сумъяабазар сайд айхтар бичиг ирүүлсэн байна лээ. Манай олгож байгаа зөвшөөрлүүдийг авах талаар бичиг байна.

С.Магнайсүрэн: Энэ асуудлыг яаралтай зохион байгуулж ажиллах.

Лхамсэржид: 1115 ААНБ-ын дэлгэрэнгүй мэдээллийн сан байгаа юу.

Б.Лхагвадорж: Хариуцсан мэргэжилтэн байгаа.

С.Магнайсүрэн: Хэрэгцээ шаардлагынхаа дагуу мэдээллийн санг бүрдүүлэх. Түрүүн би хэлсэн том хугацаагаараа 5 жил, жил болгон гэрээгээ дүгнэдэг байдлаар ажиллах нь зүйтэй байх, мөн танайх бол бүүр найман жил үйл ажиллагаа явуулсан байна. За тэгээд яаралтай үйл ажиллагааны төлөвлөгөөгөө танилцуулж ажиллъя.



Э.Хүрэлбаатар: Барилга Хот Байгуулалтын сайдын 2016 оны 12 сарын 27 ны өдрийн 200 дугаар тушаалаар батлагдсан мэргэжлийн зөвлөл нь 2016 оны 12 сарын 07 ны өдрийн БХБЯ, МАЭ-ийн хооронд байгуулсан "Архитектор, хот төлөвлөлтийн орон тооны бус мэргэжлийн зөвлөлийн чиг үүргийг гүйцэтгүүлэх тухай гэрээ"-нд үндэслэн үйл ажиллагаагаа явуулж байна. Мөн Төрийн нарийн бичгийн даргын 42 дугаар тушаалаар 21 хүний бүрэлдэхүүнтэй мэргэжлийн зөвлөл байгуулагдсан.

2019 онд 3 удаа томоохон зөвлөмж гаргаж холбогдох байгууллагуудад хүргүүлж ажилласан. 2019 онд тайлангаа ирүүлсэн байгаа. Мэргэжлийн зөвлөлийн үйл ажиллагааг хэлэлцсэн асуудлын жагсаалтын дагуу зөвлөмж гаргаж, сумдуудын ерөнхий төлөвлөгөө, хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг хэлэлцэж байгаа. Уул нь 7 удаагийн хурлаар өөрсдөө бичиг явуулж асуудлуудыг хэлэлцсэн байгаа. Цаашид сайдын албан даалгавар гаргаж ажиллах нь зүйтэй. Мэргэжлийн зөвлөл 2019 онд хэлэлцсэн асуудлуудын дийлэнх нь төрийн байгууллагуудаас ирүүлсэн хүсэлтийг хэлэлцсэн. Ингээд 2019 онд мэргэжлийн зөвлөлийн үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлсэн.

Хоёрдугаарт бол мэргэжлийн сургалтын асуудлууд байгаа. Архитектор, хот төлөвлөлийн мэргэжилтнийг давтан сургах, мэргэжил дээшлүүлэх сургалтын чиг үүргийг гүйцэтгэх тухай гэрээний дагуу сургалтыг явуулж байна.

2019.02.02-ны өдрөөс 11 удаагийн 89 багц цагийн сургалтыг явуулсан. 150 орчим архитекторууд хамрагдсан. Энэ жил монголын архитекторууд азид хүлээн зөвшөөрөгдсөн байх талаар хэд хэдэн улсуудтай уулзалт зохион байгуулсан. Удахгүй хятадтай гэрээ байгуулах гэж байгаа. Манай байгууллага 3 жил сургалтаа явуулсан учраас магадлан итгэмжлэл хамруулах хүсэлтийг тавьж ажиллаж байна. Сургалтын багш боловсон хүчний асуудал хүндрэлтэй. 61 багш нартай гэрээ байгуулан хичээл заалгаж байна. Эндээс манай архитекторууд багш нараа хүртэл сонгож ажиллаж байгаа. Сургалтаар 2019 онд 62,3 сая төгрөг төвлөрхөөс 57,5 сая төгрөг төвлөрсөн нийт 56 сая төгрөгийн зардал гарсан байгаа. Багшийн цалин болон бусад зардлууд тусгагдсан байна.

Барилгачдын нэгдсэн холбоо бас сууж байна. Гэрээ байгуулахдаа 1.1 хот төлөвлөлтийн чиглэлээрх сургалтыг зураг төсөл зохиогчдын холбоо зохион байгуулахаар зар тавиад давхар хийгээд байгаа асуудлууд байгаа. МАЭ яамтай байгуулсан гэрээний дагуу Тестийг боловсруулсан. Хот төлөвлөлтийн чиглэлээр 200 тест, зөвлөх дээр 100, мэргэшсэн 300, зөвлөх архитектор 100 гэх мэт тестүүдийг боловсруулж БХТ-д өгсөн. 1.2.3-ийн тестийг төсөвчдийн холбоотой хамтарч боловсруулсан. Ингээд тайлангаа цаг хугацаанд нь өгч байгаа. Манай гол үйл ажиллагаа бол барилгын чиглэлээр хотын өв гэсэн үйл ажиллагааг зохион байгуулж олон нийтэд танилцуулсан. Мөн барилгачдын баяр, нээлттэй хаалганы өдөрлөгүүдэд оролцлоо.

С.Магнайсүрэн: Асуух зүйл байна уу.

Ц.Баярбат: Сая төсөвчдийн холбоотой тестын асуудал ярьлаа. БХТ- үзээд буцаасан байна лээ. Төсөвчдийн холбоо автортой холбоотой асуудлууд үүссэн байгаа.

С.Магнайсүрэн: Тайлангаа өгсөн юм уу.

Э.Хүрэлбаатар: Тайлангаа 12.16-нд өгсөн байгаа.

С.Магнайсүрэн: МАЭ-тэй гэрээ байгуулаад ажиллаж байна. Өнөөдрийг хүртэл Барилгачдын нэгдсэн холбоо танайхтай давхцаж сургалт хийсэн талаар дурдлаа.

М.Батбаатар: Манайхаас бол хөтөлбөрөө батлуулаагүй байгаа.

С.Магнайсүрэн: Гэрээнүүд бол ойлгомжтой. Бүх сургалтын байгууллагуудаа танайх зөвшөөрөх ёстой. Ц.Баярбат энэ асуудлыг шийдвэрлэ.

Хоёрдугаарт сургалт явуулаад олон улсад магадлан итгэмжлэл хийж байгаа талаар ярьсан. Ер нь бол нэг маягийн зураг төсөл дээр анхаарч шинжилгээ хийх талаар шийдвэрлэсэн байгаа. Энэ асуудал дээр нилээн хамтарч ажиллах талаар ярилцсан. Эхнээс нь яах талаар ямар ажлууд төлөвлөсөн бэ.

Э.Хүрэлбаатар: Эх загвар зураг батлах тал дээр экспертизийг манай дээр хийх тал дээр ажиллах тал дээр саналаа өгч байгаа. БХТ-тэй гэрээ байгуулж ажиллах тал дээр саналаа хэлнэ.

С.Магнайсүрэн: 2020 оны төлөвлөгөөн дээр ажил хэрэгч, чанар гарахаар ажлуудыг тусгаж өгөх шаардлагатай байна. Цаашид зөвхөн сургалт биш олон ажлуудыг төлөвлөх хэрэгтэй байна.

Э.Хүрэлбаатар: Түүх соёлын дурсгалт барилгын асуудлаар манай яам дэмжихгүй гэсэн бичиг явуулсан байна лээ. Энэ асуудлыг төлөвлөгөөнд оруулаад ЗГ-р батлуулах саналтай байна. УБ хотод байгаа 161 барилга байгаа тэд нарыг оруулах шаардлагатай байна. Бүхэл бүтэн баг гаргаад судалгаатай ороод батлуулах саналтай байна.

С.Магнайсүрэн: өндөр үнэтэй орж ирсэн. Бид дэмжих талаас нь олон улсын төслүүдээс санхүүжүүлэх чиглэлээр дэмжиж ажиллана.

Чадавхижуулах сургалтыг төлөвлөгөөндөө суулгах хэрэгтэй, Мэдээллийн санд орох ёстой мэдээллүүдийг Баярбат нэгтгэж авах

А.Лхамсэржид: Би энэ ажлыг аваад 1 сар болж байна. Сарын хугацаадаас ажиллах хүчний бичгүүд их ирсэн. Энийг харахад гаднаас ажиллах хүч оруулах 2260 хүсэлт ирсэнээс манайх 1788 хүнийг дэмжиж ХНХЯ-нд саналыг хүргүүлээд байна. Энэ асуудлын талаар аж ахуйн нэгж байгууллагууд руу ярьж үзсэн. Ажилтай орлоготой олон улсын хүн бэлтгэх чиглэлээр бэлтгэх шаардлагатай байна. МАЭ олон улсын сургалтыг бэлтгэх чиглэлээр ажиллаж байгаа нь их сайшаалтай байна.

Тийм учраас олон улсын байгууллагуудтай хамтарч сургалтын хөтөлбөрийг сайжруулах шаардлагатай. Бид жилдээ 1 удаа уулзалт зөвлөгөөнүүдийг хийх хэрэгтэй байна. Эрэлт хэрэгцээтэй байгаа ажилчдаа хамтарч бэлтгэх талаар уулзалтыг хамтарч хийх саналтай байна.

Э.Хүрэлбаатар: 2019 онд японы байгууллагатай хамтарч инженерүүдээ сургалаа. Монголоос 3 оюутан шалгараад байгаа. Бас нэг хэлэхэд 2019 оны төгсгөлөөр Азийн архитекторуудын зөвлөл Монголыг зохион байгуулах хүсэлтийг манайд тавьсан. 2021 онд бүсийн форумыг монголд зохион байгуулахаар болсон. Энгийнээр хэлэхэд асем шиг л юм болдог. Монгол улсад зүүн хойд азил гадныхны том илтгэлүүд болно.

С.Магнайсүрэн: МАЭ-тай холбоотой тайлан дууслаа.

М.Батбаатар: Саяны сургалтууд дээр гомдол гараагүй Ерөнхийдөө дүгнэхдээ Барилгын салбарын сургалтууд тогтворжсон. Хоорондоо социал сувгуудийг их ашигласан. Урьд өмнө гарч байсан шиг шууд авах ёстой гэсэн шиг асуудлууд гараагүй. 43-д заасны дагуу шаадлага хангасан хүмүүс сууна гэсэн зохицуулалтууд суусан байгаа

Орон нутгийн хүмүүс өөрсдийнхөө ажилд тааруулж ирж суудаг болсон Цаашдаа сургалтуудын хөтөлбөрүүдийн хугацааг хооронд нь уялдуулж төлөвлөхөөр ажиллаж байна.

Эхлэлийг тавиал өгсөн байгаа юм бол барилгын салбарын мэргэжилтэй ажилчдыг мэргэшүүлэх ажлыг өндөр түвшинд тавьж ажиллана. ХНХЯ-ны хэмжээнд үнэ үнэлгээний төв байгуулагдсан ХНХЯ-тай гэрээ байгуулж 273 гээд 7 жилийн өмнө батлагдсан журмыг шинэчлэх ажлууд байгаа. Мэргэжилтэй ажилчдын бүртгэлийн системийг бүрдүүлэх чиглэлээр ажиллана. Цаашил энэ чиглэлээр яаж ажиллах талаар ихээхэн ажиллана. 2020 онд 188 удаагийн сургалтыг явуулах төлөвлөгөө гаргаж байна.

С.Магнайсүрэн: Шалгалтын систем бүрдсэн үү.

Ц.Баярбат: Хөргөлт агаар сэлгэлтийн тест болоогүй байгаа. Тэрийг холбоотой нь гэрээ байгуулахаар ажиллаж байна. Боловсруулах хүн олдохгүй байна.

С.Магнайсүрэн: Тэрийг энэ жилийн төлөвлөгөөнд оруул. Эн жил тестийн сангаа бүрдүүлнэ. Нийт 6500 хүн байгуу юм уу. Зөвлөх, тэргүүлэх гэх мэт хэдэн хүн байна.

Мэдээллийн сангаа бүрдүүлмээр байна. Энэ статистикаа нэгтгэж манайд өг. Төлөвлөгөөг нь эцэслэж зөвлөлөөр хэлэлцүүлнэ. 2020 оны сургалтын хэрэгцээ шаардлагыг тодорхойлох асуудлууд байна. 16 сургуулиудтай хэлэлцүүлэг хийх асуудлыг бол дэмжиж байна. Баклавын сургалт, мэргэшүүлэх сургалтын асуудлыг хэлэлцэх. Мэргэжилтнүүдийн судалгааг нэгтгэх.Цаашид шинэ шатанд гаргах асуудлын талаар МАЭ танай 2 идэвхитэй ажилламаар байна. Шалтгалтын асуудлууд дээр гомдол бол бага гарч байгаа гэсэн.

Д.Баярсайхан: Мэргэжлийн зөвлөлийн гишүүдийг шинэчлэх асуудлыг хэлэлцэх хэрэгтэй байна. Боловсролын яаман дээр боловсруулагдаж байгаа индекс дээр анхаарч ажиллах хэрэгтэй байна.

С.Магнайсүрэн: Энэ асуудлыг төлөвлөгөөнд суулга.

Лхамсэржид: хуучин үндэсний хороо Сургуулиуд ИТА-ынхаа мэдээллийг өгдөг байсан. ХНХЯ-аас ажилчдын зэрэг дэв гэж ярьлаа. Ер нь бол сургалтын бүтэц гаргамаар байна. Тэр хүмүүс нь нэгдсэн зохицуулалтанд оруулмаар байна. Нөгөө талаас ажиллах хүчний мэдээлэл орж ирдэг мэдээллийн санд орж ирдэг байх хэрэгтэй байна. Тэрнээс бүх мэдээллүүд ороод компаниуд ажиллах хүчээ авдаг байх хэрэгтэй гэж бодож байна.

М.батбаатар: Шинээр ажил авсан Лхамсэрждэд бас баяр хүргье. ИТА-ыг бол бүртгэлийг цэгцэлсэн. Мэргэжилтэй ажилчдын асуудал дээр ХНХЯ-ын институтад нилээн мэдээлэл өгсөн. Барилгын салбарын мэргэжилтэй ажилчдын мэдээллийн санг бүрдүүлэх асуудлыг цэгцлэх талаар яаманд нилээн саналыг өгсөн. Хэдүүлээ нийлж байгаад 2020 оны төлөвлөгөөнд тусгаад ажиллах саналтай байна.

төлөвлөж оруулж ирэх. Эдний төлөвлөгөөг төсөвтэй оруулж ирэх. Ажил хэрэгч байдлаар төлөвлөгөөгөө оруулж ирээрэй.

### ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

1. "Монголын барилгын үндэсний ассоциаци" ТББ-аар төрийн зарим чиг үүргийг гэрээнийн үндсэн дээр гүйцэтгүүлж буй гэрээний хугацааг сунгах Барилга, хот байгуулалтын сайдын тушаалын төсөл бэлтгэх, холбогдох төсөв, төлөвлөгөөг хянаж танилцуулах; /ББМҮБХЗГ/
2. "Монголын барилгын материал үйлдвэрлэгчдийн холбоо" ТББ-аар төрийн зарим чиг үүргийг гэрээнийн үндсэн дээр гүйцэтгүүлж буй гэрээний хугацааг сунгах Барилга, хот байгуулалтын сайдын тушаалын төсөл бэлтгэх, холбогдох төсөв, төлөвлөгөөг хянаж танилцуулах; /ББМҮБХЗГ/
3. "Монголын архитекторуудын эвлэл" ТББ-аар төрийн зарим чиг үүргийг гэрээнийн үндсэн дээр гүйцэтгүүлж буй гэрээний хугацааг сунгах Барилга, хот байгуулалтын сайдын тушаалын төсөл бэлтгэх, холбогдох төсөв, төлөвлөгөөг хянаж танилцуулах; /ТЗУГ/
4. "Монголын барилгачдын нэгдсэн холбоо" ТББ-аар төрийн зарим чиг үүргийг гэрээнийн үндсэн дээр гүйцэтгүүлж буй гэрээний хугацааг сунгах Барилга, хот байгуулалтын сайдын тушаалын төсөл бэлтгэх, холбогдох төсөв, төлөвлөгөөг хянаж танилцуулах; /ТЗУГ/
5. Бусад өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг гаргаж танилцуулах. /ТЗУГ, ББМҮБХЗГ/

Танилцсан:  
ТӨРИЙН НАРИЙН  
БИЧГИЙН ДАРГА


Хянасан:  
ТЗУГ-ын дарга

БТГ-ын дарга

ББМҮБХЗГ-ын даргын үүргийг  
түр орлон гүйцэтгэгч

Тэмдэглэл хөтөлсөн:  
ТЗУГ-ын ахлах шинжээч

ББМҮБХЗГ-ын ахлах шинжээч



С.МАГНАЙСҮРЭН

Д.Баярсайхан

Ц.Баярбат

Б.Гантулга

А.Лхамсэржид

Д.Батзориг